

ЗАСАГ ДАРГА

БАТЛАВ

М.БАДАМ

## СУРГУУЛИЙН ГАДНА ТОХИЖИЛТЫН АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

*Бүрэгхангай сумын ерөнхий боловсролын сургуулийн гадна тохижилт хийх ажил:*

А. Ажил гүйцэтгэх хугацааны график хөдөлмөр зарцуулалт, ургэлжлэх хугацаа/ажлын график/, ажиллах хүчний тоог тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи аргачлал, техникийн тодорхойлолтыг боловсруулсан байна.

Б. Барилгын норм ба дүрэм /БНБД/ стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэх

В. Үнийн тарифийг тооцон ирүүлэхдээ ажилбар тус бүрээр тооцох.

Г. Талбайн зохион байгуулалтын зураг, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангах төслийн баримт бичгийг тухайн ажилд нийцүүлэн боловсруулах.

### 1. Талбайн газар шороо, бетон цутгалтын ажил

Барилгын газар шороо, буурь суурийн ажлыг гүйцэтгэхэд БНБД 3.02.01-90-г баримтална.

Талбай хийх газрыг нэлэнхүйд нь жигдлэн түрж тэгшлэх, сул шороог хийн тромбовкоор нягтруулах шаардлагатай. Гадаргуун тэгшилгээ, нягтруулалтыг бүрэн хийсний дараа дараагийн үе шатны ажлыг эхлүүлнэ.

### 2. Талбайн төмөр хашааны ажил

Талбайн хашааны өндөр 1,2м-тэй байх ба шон хоорондын зай 2м-ээс ихгүй, хамгийн багадаа 50см-ын гүнд цутгаж суурилуулна. Бага насны хүүхдүүд хашааруу авирч торыг гагнаасаар нь салгах, салхины үйлчлэл ихтэй тул хашаа ханарч нурах нурах асуудал их гардаг тул торыг их рамтай нь бэхэлж полсвой төмрөөр бүслүүрдэн гагнах болон хашааны хөшүүн чанарыг сайтар хангах шаардлагатай.

### 3. Ногоон байгууламжийн хашаа солих ажил

Хашааны өндөр 80см-тэй байх ба шон хоорондын зай 2м-ээс ихгүй, хамгийн багадаа 40см-ын гүнд цутгаж суурилуулна.

#### Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:

1. Талбайн тохижилтын ажлыг батлагдсан төсөв, ажлын тоо хэмжээний дагуу чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ.



2. Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, БНБД, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.
3. Импортын материал сонгон худалдан авах тохиолдолд тохирлын гэрчилгээ, сертификат, паспорт, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргана. Үндэсний Үйлдвэрийн материал сонгон авбал Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ, лабораторийн шинжилгээний дүн, үнийн баримтыг хавсаргана.
4. Барилгын талбайд хэрэглэгдэж буй материалын лабораторийн сорилтын дүн, тохирлын гэрчилгээ, гарал үүслийн бичиг баримтуудыг бэлэн байлгах шаардлагатай.
5. Талбайн угсралтын ажлыг чанаргүй гүйцэтгэсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгнө.
6. Барилгын тухай хуулийн 14.3-т заасны дагуу ашиглалтанд хүлээлгэн өгснөөс хойш зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна. Энэ хуулийн 14.6 заасны дагуу 14.3- т заасан хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна.
7. Гүйцэтгэсэн ажлыг ил, далд ажлын акт, схем зураг, фото зургаар баталгаажуулсан байна.
8. Энэхүү техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, эрх бүхий улсын байцаагч эрхийнхээ дагуу тухайн ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй болно.

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ ХЯНАСАН:

БҮРЭГХАНГАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Ц.МӨНХТУЛГА

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОВСРУУЛСАН:

БҮРЭГХАНГАЙ СУМЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО,  
ХҮНИЙ НӨӨЦИЙН АЖИЛТАН

В.БАТХУЯГ



БҮРЭГХАНГАЙ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ГАДНА  
ТОХИЖИЛТ ХИЙХ АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ

2024.03.20


Дархан баг

| №   | Гүйцэтгэх ажлын нэр   | Хэмжих нэгж | Тоо хэмжээ |
|---|---|-------------|------------|
| Талбайн газар шороо, бетон цутгалтын ажил |   |             |            |
| 1   | Талбайн овгор хэсгийг механизмаар түрэх, цутгалт хийх                       | М2          | 548        |
| 2   | Шороог гараар тарааж тэгшлэх  | М3          | 10         |
| Талбайн төмөр хашааны ажил                |   |             |            |
| 1   | Хашааны приметр 1,2м өндөртэй төмөр шонтой хашааг суурийн хамт цутгах       | М3          | 108        |
| 2   | Хашааны төмөр шонг өнгийн сурик будгаар 2 удаа будах                        | Кг          | 10         |
| Ногоон байгууламжийн хашаа солих          |   |             |            |
| 1   | Хашааны приметр 80см өндөртэй төмөр шонтой төмөр хашааг суурийн хамт цутгах | М3          | 72         |
| 2   | Хашааны төмөр шонг өнгийн сурик будгаар 2 удаа будах                        | М3          | 8          |



# СУРГУУЛИЙН СХЕМ ЗУРАГ

1-ДУГААР ДАВХРЫН БАЙГУУЛАЛТ



1. Хашааны хайс солих, сунгах 32м, хайсны өндөр 1.2м
2. Заалны хажуу талын хэсэгт хар шороо дэвсэх
3. Ногоон байгууламжийн хайс солих, өндөр нь 80см, 25м Хайс

## Сургуулийн гадна

### ТОХИЖИЛТ

- Хайс хийгдэх ногоон байгууламж
- Одоо байрлаж буй талбай
- Цутгалт хийгдэх талбай